| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 113,600.00 | 113,600.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **0.00** | **20,000,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 20,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1,851,043.00** | **7,000,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **1,851,043.00** | **7,000,000.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,351,043.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 500,000.00 | 7,000,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **0.00** | **675,571.30** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | | 675,571.30 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **326,654,891.28** | **617,682,100.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 326,654,891.28 | 617,682,100.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 326,654,891.28 | 617,682,100.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | **0.00** |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бүртгэл санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Оргилмөрөн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орхон аймгийн Хот тохижуулах газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Эрхэм зорилго: Эрдэнэт хотын хүн амыг амгалан тайван, аюулгүй, тав тухтай, цэвэр орчинд амьдруулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын хууль тогтоомж, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ТБОНӨХБАҮХАТхууль зэрэгт өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурииар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийн нийт зардал ба цэвэр зээлийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл **дунд** гэж үнэлэн аудитын цар хүрээ, цаг хугацааны нөхцөл байдлыг харгалзан материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 4,672,626.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 70,089.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 52,567.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орхон аймгийн Хот тохижуулах газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,034,636.4 мянган төгрөгөөр буюу 19.5 хувиар өссөн байна. Нийт хөрөнгийн өсөлт нь тайлант оны бараа материал, үндсэн хөрөнгийн өсөлттэй холбоотой байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 28,225.1 | 21,790.8 | -6,434.3 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 146,568.0 | 150,379.4 | 3,811.4 |
| Үндсэн хөрөнгө | 30,801,073.5 | 36,838,332.8 | 6,037,259.3 |
| **Нийт хөрөнгө** | **30,975,866.6** | **37,010,503.0** | **6,034,636.4** |
| Өр төлбөр | 52,965.7 | 26,693.6 | -26,272.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | **30,922,900.8** | **36,983,809.4** | 6,060,908.6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **30,975,866.5** | **37,010,503.0** | **6,034,636.4** |

Мөнгөн хөрөнгийн данс эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Авлагын эцсийн үлдэгдэл 21,790.8 мянган төгрөг болж 6,434.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд авлагын үлдэгдлийг

барагдуулсан боловч тайлант онд ХХОАТ-ын 21,790.8 мянган төгрөгийн авлага үүсгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 150,379.4 мянган төгрөг болж 3,811.4 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материалын болон бусад хангамжийн материалын өсөлттэй холбоотой байна. Тайлант онд 34,594.6 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 36,838,332.8 мянган төгрөг болж 6,037,259.3 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь тайлант хугацааны элэгдлийн зардал 5,157,124.4 мянган төгрөгөөр буурсан ч үнэ төлбөргүй хүлээн авсан 11,240,559.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн тул дансны үлдэгдэл өссөн байна. Энэ нь зам гүүрний байгууламж 6,663,402.9 мянган төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 4,487,326.2 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 26,693.6 мянган төгрөг болж 26,272.2 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн хүрээнд өр төлбөрийн эхний үлдэгдлийг төлж барагдуулсан боловч оны эцэст өвөлжилтийн бэлтгэж ажил хангахтай холбоотой өр төлбөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 36,983,809.4 мянган төгрөг болж 6,060,908.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Орхон аймгийн Хот тохижуулах газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 5,937,180.5 мянган төгрөгөөр буюу 55.9 хувиар өссөн байна. Өмнөх оноос орлого өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон орон нутгийн төсвийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлогоос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 248,959.0 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан ндш, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, төвлөрүүлэх шилжүүлэг байна. Энэ нь тайлант онд ндш-ийн зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал, үйл ажиллагааны бус зардал өссөн бол эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардал буурсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,668,263.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,968,263.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 295,637.2 мянган төгрөгөөр бууруулж, тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 4,672,626.1 мянган төгрөгөөр тооцон баталж төсөвлөсөн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71502 /Хот байгуулалт, тохижилт/ хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,672,626.1 мянган төгрөгийн төсөв

баталснаас 275,122.9 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас, 4,397,503.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,667,476.5 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 389.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 714.8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 126.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 216.4 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 423.6 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 2,879.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 397.8 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө ангиллаар 617,682.1 мянган төгрөг хүлээн авч холбогдох зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулах хүсэлт гаргаж хуваарилуулан зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 675.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

Орхон аймгийн Хот тохижуулах газрын төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 142 талбарын мэдээлэл, 9 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 932,256.9 мянган төгрөгийн 13

гүйлгээ, зарлагын 1,041,720.0 мянган төгрөгийн 32 гүйлгээг дутуу мэдээлсэн, мөн зарлагын 65,321.5 мянган төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож 11-р сард нөхөж мэдээлсэн байна. 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 197,012.9 мянган төгрөгийн 17 худалдан авалтыг мэдээлээгүй, 2 худалдан авалтыг өссөн дүнгээр 244,699.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн, 481,463.4 мянган төгрөгийн худалдан авалтыг өссөн дүнгээр бус сар сард нь мэдээлсэн байна. Тендерийн ерөнхий мэдээлэл болон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг алдаатай мэдээлж байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 760.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт бүрэн төлөгдсөн, 79,210.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 1 албан шаардлага, мөн аудитаар хүргүүлсэн 5 зөвлөмжийн биелэлт хангагдсан бөгөөд биелэлт дутуу хангагдсан зөвлөмжийн хүрээнд тайлант оны аудитаар албан шаардлага хүргүүллээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орхон аймгийн Хот тохижуулах газрын санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй ба дараагийн аудитаар бараа материал, үндсэн хөрөнгийн дансыг авч үзэж болох юм.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 965,481.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 906,722.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,050.8 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 31,135.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 25,573.3 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн дансны 617,682.1 мянган төгрөгийг улсын төсвийн Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт ангиллаар 5,149.6 мянган төгрөгийн болон 675.6 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийн дансны ангиллыг тус тус алдаатай илэрхийлсэн, мөн нэмэлт санхүүжилтийн дансны 638.0 мянган төгрөгийн орлогыг дутуу бүртгэсэн байна.
- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 26,300.0 мянган төгрөгийг холбогдох зардлуудын ангиллаар, төлбөр хураамжийн 5,000.0 мянган төгрөгийг мэдээлэл, технологийн үйлчилгээ зардлын ангиллаар тус тус алдаатай илэрхийлсэн байна.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд цалин хөлсний зардлыг 140,209.3 мянган төгрөгөөр, тээвэр шатахууны зардлыг 20,112.6 мянган төгрөгөөр, төлбөр хураамжийг 23,384.9 мянган төгрөгөөр тус тус дутуу, ндш-ийн зардлыг 24,710.4 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 2,350.4 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардлыг 40,509.1 мянган төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн байна.

### 4.2 Төлбөрийн акт

1. Нэмэлт санхүүжилтийн дансаар 2021 оны 7-р сард Экохүрээ ХХК-аас худалдан авсан авто замын асфальтын үнийг нэхэмжлэхийн дүнгээс 1,686,176 төгрөгөөр илүү дүнгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Төлбөрийн акт тогтоов

2. Тайлант онд ажилчдын цалингаас суутгасан дүнгээс  жилийн дүнгээр үйлдвэрчний эвлэлийн хороонд 164,581 төгрөг, улаан загалмайн нийгэмлэгт 200,000 төгрөг буюу нийт 364,581 төгрөгийг суутгасан дүнгээс зөрүүтэй болон холбогдох ажилтнаас суутгалгүйгээр илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Төлбөрийн акт тогтоов

### 4.3 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд оруулбал зохих 151 талбарын мэдээллээс хугацаандаа оруулсан 142 талбарын мэдээлэл, 9 талбарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш орлогын 932,256.9 мянган төгрөгийн 13 гүйлгээ, зарлагын 1,041,720.0 мянган төгрөгийн 32 гүйлгээг дутуу мэдээлсэн, мөн зарлагын 65,321.5 мянган төгрөгийн 5 гүйлгээг хугацаа хоцроож 11-р сард нөхөж мэдээлсэн байна. 5 сая төгрөгөөс дээш худалдан авалтын 197,012.9 мянган төгрөгийн 17 худалдан авалтыг мэдээлээгүй, 2 худалдан авалтыг өссөн дүнгээр 244,699.9 мянган төгрөгөөр дутуу мэдээлсэн, 481,463.4 мянган төгрөгийн худалдан авалтыг өссөн дүнгээр бус сар сард нь мэдээлсэн байна. Тендерийн ерөнхий мэдээлэл болон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг алдаатай мэдээлж өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4-д “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг”, 6.4.5-д “ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Албан шаардлага өгөв.

2. Тус байгууллага нь өмнөх онуудад үүссэн авлага, өр төлбөрийг барагдуулсан боловч, тайлант онд ХХОАТ-ийн 21,790.8 мянган төгрөгийн авлага /ХХОАТ-нд буруу гаргаж хүргүүлсэн тул авлагын дүн алдаатай/, нэн шаардлагатай өвөлжилтийн бэлтгэл ажил хангах давс, цас хайлуулах бодис нөөцөлж бэлтгэхээс бусад 7,093.5 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүсгэсэн, НДШ-ийн тайланд цалингийн зардлыг 2,250.7 мянган төгрөгөөр илүү мэдүүлсэн, цалингийн зардлаас гүйлгээ хийсэн төлбөрийн хүсэлтийн дүнгээр НББ-н цалингийн зардлыг бүртгэж өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u>Албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант оны жилийн дүнгээр цалингийн зардлаас АО-с төлөх НДШ-ийн зардалд 9,153.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 506.5 мянган төгрөг тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй, Сангийн сайдын 2018 оны 134 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6-д “Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр цалин, АО-с төлөх НДШ-ийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

***2. Зардлын данстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Хот тохижуулах газрын 2016, 2017 оны цалингийн дүнд ҮОМШӨ даатгалын шимтгэлийг Засгийн газрын 2008 оны 142 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан хувь хэмжээнээс дутуу тооцсон гэсэн зөрчлийн хүрээнд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021.12.24-ны өдрийн 20/87 дугаар улсын байцаагчийн актаар дутуу тооцсон шимтгэл, түүнд ногдох алдангийн хамт нийт 37,638.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр тогтоож төлсөн байна. ҮОМШӨ даатгалын шимтгэлийг тогтоосон хувь хэмжээгээр ажил олгогчоос тооцож төлдөг боловч аль аль талын хариуцлагагүй байдалтай холбоотойгоор алдангийн дүн болох 4,265.2 мянган төгрөгийн шаардлагагүй нэмэлт зардал гарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Төсвийн хөрөнгөөр холбогдох ажилтнуудын хариуцлагагүй байдалтай холбоотой үүссэн алдангийн зардлыг санхүүжүүлж нэмэлт үр ашиггүй зардал гаргахгүй байх, төсвийн зориулалт бус зарцуулалт болох алдангийн зардлыг үл хүлээн зөвшөөрөх эсхүл буруутай этгээдэд хариуцуулах.

***3. Зардлын данстай холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Нэр данс зөрүүгийн орлогоос Төрийн сангийн 300015 - кодтой эдийн засгийн ангиллаар 230.0 мянган төгрөгийн зардал 2021.09.26-нд нэмэлт данснаас гаргасан боловч тус дүн нь орлогоор орж ирээгүй, харин 2021.04.02-нд 203.0 мянган төгрөг, 2021.08.05-нд 14.0 мянган төгрөгийн орлого орж ирсэн байна. Төрийн сангийн дансны хуулгаар 2021.09.28-нд 300015 кодод тус 230.0 мянган төгрөгөөр санхүүжилтийн орлого хуваарилсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

*3.2. Өгсөн зөвлөмж:*

Буцсан гүйлгээний болон нэмэлт орлогыг дансны хуулгаар хянан баталгаажуулж, тодорхой бус болон буцаан дамжуулж шилжүүлэх орлогыг журамд заасан хугацаанд буцаан шилжүүлж хэвших.

***4. Зардлын данстай холбоотой асуудал***

*4.1. Илрүүлэлт:*

Ажилчдын цалингаас үүрэн телефоны операторын төлбөрийн суутгал хийж буй бөгөөд суутгасан дүнгээр сар бүр шилжүүлээгүйтэй холбоотойгоор жилийн дүнгээр мобикомын суутгалыг 94.1 мянган төгрөгөөр, юнителийн суутгалыг 153.6 мянган төгрөгөөр тус тус дутуу шилжүүлсэн байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119.1-д “Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно” гэсэн заалтад нийцэхгүй буюу тус хуулийн 119.1.1-119.1.4-д заасан суутгалд дээрх суутгал нь хамаарахгүй байна.

*4.2. Өгсөн зөвлөмж:*

Ажилтнуудын цалингаас Хөдөлмөрийн тухай хуулиар тодорхойлсноос бусад төрлийн суутгал хийхгүй байх, хууль тогтоомжид заасны дагуу ажилтны цалин хөлснөөс суутгал хийх тохиолдолд ажилтанд урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авсан байх.

***5. Зардлын данстай холбоотой асуудал***

*5.1. Илрүүлэлт:*

Тайлант оны бодогдсон цалинг ХХОАТ-ын тайланд 1,269.6 мянган төгрөгөөр дутуу мэдүүлсэн, цалингийн нэгдсэн системээр бодогдсон цалингаас суутгасан ХХОАТ-н өглөгийг татварын тайланд хуульд тодорхойлсон хөнгөлөлтийг дутуу тайлагнах, мэдээллийг алдаатай бэлтгэх зэргээр 9,901.1 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Татварын ерөнхий хуулийн 29.1.3-д “суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*5.2. Өгсөн зөвлөмж:*

НДШ-ийн болон цалин хөлсний ХХОАТ-ын тайланг бодогдсон цалин, цалингаас суутгасан татвар, шимтгэлийн дүнтэй сайтар тулган шалгаж, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг зөв тооцож, НДШ, ХХОАТ-ын тайланг үнэн зөв гарган хүргүүлж, ажлын хариуцлагыг шат шатандаа сайжруулж тайлант онд алдаатай тайлагнасан тайланг хүсэлт гаргаж засварлаж, авлагын дүнг бодитой тооцож тулган баталгаажуулж залруулж бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Хот тохижуулах газар | 1 | 31,135.0 | | | | | 1 | 31,135.0 | | |
| 2 | Хот тохижуулах газар | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | |
| 3 | Хот тохижуулах газар | 1 | 1,686.2 | | | 1 | 1,686.2 | | | | |
| 4 | Хот тохижуулах газар | 1 | 364.6 | | | 1 | 364.6 | | | | |
| 5 | Хот тохижуулах газар | 1 | 9,659.7 | | | | | | | 1 | 9,659.7 |
| 6 | Хот тохижуулах газар | 1 | 4,265.2 | | | | | | | 1 | 4,265.2 |
| 7 | Хот тохижуулах газар | 1 | 230.0 | | | | | | | 1 | 230.0 |
| 8 | Хот тохижуулах газар | 1 | 247.7 | | | | | | | 1 | 247.7 |
| 9 | Хот тохижуулах газар | 1 | 11,170.7 | | | | | | | 1 | 11,170.7 |
| 10 | Хот тохижуулах газар | 1 | 624,145.3 | 1 | 624,145.3 | | | | | | |
| 11 | Хот тохижуулах газар | 1 | 31,300.0 | 1 | 31,300.0 | | | | | | |
| 12 | Хот тохижуулах газар | 1 | 251,276.7 | 1 | 251,276.7 | | | | | | |
| **Дүн** | | **12** | **965,481.1** | **3** | **906,722.0** | **2** | **2,050.8** | **2** | **31,135.0** | **5** | **25,573.3** |